Golomt Capital®
Delivering diversity

Interactive Brokers

# ТОЙМ



## ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2024.11.04

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль.
- АНУ-д өнгөрсөн сард ердөө 12,000 ажлын байр нэмэгдэв.
- Технологийн компаниудын хиймэл оюун ухаанд оруулж буй өндөр зардал нь ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Хятадын PMI 10-р сард 49.8-аас 50.1 болж нэмэгдэв.
- 2025 оны Хятадын эдийн засгийн төлөв тогтвортой байна.
- Хэрэв Trump ялбал Хятадын эдийн засгийн дэмжлэгийн багц төсөөлснөөс 10-20%-иар илүү том байх боломжтой

2024 он 11-р сарын 04

| | |
|---|---|
| Dow Jones | 42,052.19 |
| S&P 500 | 5,728.80 |
| Nasdaq | 18,239.92 |
| DAX | 19,254.97 |
| FTSE 100 | 8,177.15 |
| S&P/ASX 200 | 8,165.60 |
| HANG SENG | 20,528.00 |

### АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | 0.69% | -0.79% | -0.71% | 11.58% | 23.46% | 15.76% |
| S&P 500 | 0.41% | -1.63% | -0.39% | 20.10% | 31.44% | 21.95% |
| Nasdaq | 0.80% | -1.76% | 0.56% | 21.51% | 35.33% | 14.20% |

2024 оны 11 сарын 04-ний 11:10

### Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| DAX | 0.93% | -1.42% | 0.70% | 14.94% | 26.77% | 19.94% |
| FTSE 100 | 0.83% | -1.31% | -1.25% | 5.74% | 10.24% | 11.96% |

2024 оны 11 сарын 04-ний 11:10

### Ази Номхон далайн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | 0.53% | -0.66% | 0.21% | 7.59% | 17.04% | 9.53% |
| Hang Seng | -0.19% | -0.37% | -9.73% | 20.39% | 16.19% | -17.48% |

2024 оны 11 сарын 04-ний 11:10

## ЗӨВЛӨМЖ

**АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль 2024:**

Монголын цагаар лхагва гараг буюу 11-р сарын 6 өглөө 07:00 цагаас АНУ-ын 60 дахь удаагийн сонгуулийн үр дүн зарлагдана.

Энэ долоо хоногт зах зээл маш өндөр савлагаатай байх бөгөөд хөрөнгө оруулагч та бүхэн эрсдэлээ тооцон арилжаанд оролцоорой.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**АНУ-ын зах зээлд тогтворгүй байдал үүсэв**
Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын голлох хувьцааны индексүүд эдийн засгийн болон 3-р улирлын тайлангуудаас хамааран ихэнх нь буураад байна. Технологид суурилсан Nasdaq индекс долоо хоногийг өсөлтөөр эхлүүлсэн ч долоо хоногийн төгсгөлд хүчтэй уналаа.

Эдийн засгийн чухал үзүүлэлтүүд болох ажилгүйдлийн түвшин болон NFP мэдээнүүд зарлагдсанаар зах зээл тэр чигээрээ унав. Харин энэ долоо хоногт АНУ-ын 60 дахь удаагийн ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн гарч, ХНС бодлогын хүүгийн шийдвэрээ танилцуулна. Иймд зах зээл маш тогтворгүй байдалтай байна.

**Тайлангууд сайн гарсан ч хувьцаанууд унав**
Microsoft, Meta, Apple, Amazon зэрэг технологийн компаниуд тайлангаа танилцуулж хэдийгээр таамаглалаас дээгүүр байсан ч ирэх улирлуудад хиймэл оюун ухааны салбарт гаргаж байгаа зардлууд ихэснэ гэж үзэн хүчтэй унаад байна. Amazon-ийн хувьд үүлэн технологийн нэгжийн өсөлтөөр орлогын таамгийг давсан бол Apple компани iPhone борлуулалтын өсөлтөөр борлуулалт таамаглалаас дээгүүр байсан ч цэвэр ашиг хүлээлтэд хүрсэнгүй.

**АНУ-ын хөдөлмөрийн зах зээл гайхмаар үзүүлэлтийг харууллаа**
10-р сард гарсан хар салхинууд болон Boeing компанийн ажил хаялт нь ажлын байрны өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна. Өнгөрсөн сард ердөө 12,000 ажлын байр нэмэгдсэн нь таамаглал болох 100,000-аас маш бага үзүүлэлт боллоо. Харин ажилгүйдлийн түвшин 4.1%-д тогтвортой байв.

**АНУ-ын ерөнхийлөгчийн сонгууль**
Монголын цагаар лхагва гараг буюу 11-р сарын 6 өглөө 07:00 цагаас АНУ-ын 60 дахь удаагийн сонгуулийн үр дүн зарлагдана. Урьдчилсан таамаглалаар Donald Trump ялах магадлал өндөр байгаа ба хэрэв тэрээр ялбал орлогын албан татварыг үгүй болгож, BTC болон Tesla-д эерэг нөлөө үзүүлнэ.

**График 1: АНУ-ын Nasdaq100 индексийн ханшийн таамаглал**



# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Сүүлийн долоо хоногт Хятадын хөрөнгийн зах зээлд уналт ажиглагдав. Үндэсний статистикийн мэдээллээр эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлсэн ч Хятадын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд бууралттай байлаа. Шанхайн Композит Индекс 0.84%-иар унаж ХонгКонгийн Hang Seng индекс 0.41%-иар унажээ.

**Үйлдвэрлэлийн салбарын өсөлт**
Хятадын үйлдвэрлэлийн салбар энэ оны дөрөвдүгээр сараас хойш анх удаа өсөлттэй гарчээ. (PMI) 10-р сард 49.8-аас 50.1 болж нэмэгдэж, өсөлт, агшлын зааг болсон 50 оноог давсан байна. Хувийн хэвшлийн Caixin/S&P Global-ийн үйлдвэрлэлийн PMI мөн 10-р сард 49.3-аас 50.3 болж өссөн байна.

**Үл хөдлөх хөрөнгийн салбар**
Хятадын томоохон 100 хөгжүүлэгчийн шинэ орон сууцны борлуулалтын дүн өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 7.1%-иар өссөн бөгөөд энэ нь 9-р сард 37.7%-иар унаж байсан үзүүлэлттэй харьцуулахад ихээхэн ахиц гаргасан үзүүлэлт юм. 2024 онд анх удаа 10-р сард үл хөдлөхийн салбар өсөлттэй гарлаа. Шинжээчид 2025 оны Хятадын эдийн засгийн төлөв ихээхэн сайжирсан гэж үзэж байгаа бөгөөд эдийн засаг эргэн өсөхгүй ч дор хаяж тогтвортой байх төлөвтэй гэжээ.

**АНУ-ын Ерөнхийлөгчийн Сонгууль ба Хятадын зах зээлийн хүлээлт**
Хятад улс эдийн засгийн дэмжлэгийн багц арга хэмжээний талаар 11-р сарын 8-ны өдөр зарлах төлөвтэй байна. АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг харгалзан багц арга хэмжээгээ зарлахаар Хятадын эрх баригчид төлөвлөжээ. Nomura-ийн Хятадын ахлах эдийн засагч Тинг Лу “Хэрэв Трамп ялбал Хятадын эдийн засгийн дэмжлэгийн багц төсөөлснөөс 10-20%-иар илүү том байх боломжтой” гэжээ. Харин WisdomTree-ийн куант хөрөнгө оруулалтын захирал Ликиан Рен дэмжлэгийн цар хүрээ нь сонгуулийн үр дүнгээс илүүтэйгээр хөрөнгийн зах зээлийн хариу үйлдлээс хамаарна гэж үзэж байна.

### График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



# ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**




**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

